

МЕНТАЛИТЕТ ХЭМЭЭХ ОЙЛГОЛТЫН ФИЛОСОФИЙН УТГА ХОЛБОГДОЛ

Г.Лодой- МУИС, НШУС, Философийн тэнхим
В.И.Павлов- МУИС, ГХСС, Орос судлалын тэнхим

Түлхүүр үг: менталитет, нийгэм соёлын өөрчлөлт, оюун санаа, ухамсар, иррационал болон рационал шинж

ХХ зуунаас өмнө нийгмийн ухамсар, сэтгэхүйн онцлог, хүний үйл ажиллагаа түүний зан авирын иррационал сэдэл, үндэсний үзэл санааг бүрэлдүүлэхтэй холбоотой үйл явцыг хүмүүнлэгийн ухаанд “менталитет” хэмээх ойлголттой холбонтайлбарладаггүй байсан ажээ. Уг ойлголт нь хүний оршихуйн бүх хүрээний үзэгдлийг цогц илэрхийлэх зорилттой уялдаатай юм. Нийгэм соёлын байдал өөрчлөгдөж, хүн төрөлөхтөн геободлогын, оюун санааны, антропологийн өөрчлөлт орж, “янз бүрийн бус нутгийн ба үеийн ухамсарууд хоорондоо холбогдож”¹ эхэлснээр менталитет хэмээх ойлголт гарч ирэх шалтгаан болсон гэж үзэж болох юм. Нийгмийн ба хувийн ухамсарын өөрчлөлт нь өнөө үед ухааран ойлгох үйл явцыг шаардаж байгаа ба өрчин үеийн онтологийн үүднээс шинэ нэр томьёогоор илэрхийлэх шаардлага бий болсон гэж үзэж болох юм.

Янз бүрийн ард түмэн, тэдний соёл, амьдралын хэв маяг нь түүхийн хувьд хоорондоо ялгаатай субъектууд юм. Нийгмийн философи, соёлын философи, философи антропологи энэхүү хоорондын ялгааг зөвхөн рациональ бус мөн иррациональ илэрхийллээр судалдаг ба үл ухамсарлахуйн давхрагын гүндэх үеийг нээхэд чиглэгдсэн ажээ.

“Менталитет” хэмээх ойлголтыг бүрэлдэн тогтох үйл явцыг этимолог, гносеолог ба онтологийн үүднээс тайлбарлах нь зүйтэй юм.

Уг категорийг этимологийн үүднээс олон талаас тайлбарлаж болох юм. Латин хэлэнд “mens, mentis-alis” гэдэг нь ухаан -ум, сэтгэхүй- мышление, оюун ухаан -разум сэтгэлгээний хэв маяг – образ мыслей, санаа – мнение, сэдэл – намерение, эргэцүүлэл – размышление гэх мэтийн утга илэрхийлдэг юм. Герман хэлэнд “mentalitaet-en” – оюун ухааны хэв маяг – склад ума, сэтгэлгээний хэв маяг – образ мыслей . Англи хэлэнд “mentality” – ухаан - ум, оюун - интеллект, оюун ухаан -разум, ухааны хэв маяг -склад ума, оюун ухааны төлөв байдал - умонастроение, үзэл бодол -точка зрения. Франц хэлнээс “mentalita” 1) сэтгэхүйн чиг санаа- направление мыслей, оюун ухааны төлөв байдал (умо)настроение, оюун ухааны хандлага -направленность ума; 2) ухаан - ум, оюун ухааны чадвар - умственные способности; оюун ухааны хөгжил - умственное развитие, оюун түвшин - интеллектуальный уровень; оюун ухааны хэв маяг -склад ума; сэтгэхүй мышление; сэтгэлзүй - психика; сэтгэлзүй - психология. Испанияар “mentalidad” – 1) ухаан -ум, оюун ухааны (сэтгэхүйн)- умственные (мыслительные), 2) оюун - интеллект оюун ухаан- разум, оюун ухааны хэв маяг - склад ума. 3) Оюун ухааны хэв маяг- обра мыслей гэдэг утга санааг илэрхийлдэг юм.

Уг нэр томьёог этимологийн үүднээс ийм өргөн хүрээний утга илэрхийлж байгаа нь түүнийг ойлгох асуудлыг нилээд хүндрүүлдэг юм. Гэвч юуны өмнө дараах зүйлий тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд: “менталитет” гэдэг ойлголтыг тайлбарлаха, юуны түрүүнд ухаан, оюун ухааны хэв маяг, оюун, сэтгэхүй гэдэг ойлголтууды

¹ Библер В.С. Итоги и замыслы: Контекст философской логики культуры // Вопросы философии. 1953. №5. с. 75

хэрэглэж байгаа нь хүний оюун ухааны үйл ажиллагаа, түүний сэтгэхүйн үйл явц, ухамсарыг хөндөж байгаа ажээ.

“Менталитет” хэмээх ойлголт гносеологийн хувьд бүрэлдэн тогтох үед түүний утга санааг үндэсний ухамсар, ухамсар, сэтгэхүй, сэтгэлзүй, санаа, ард түмний сүнс г.м. ойролцоо угагтай ойлгоор дамжуулж байжээ.

Янз бүрийн ард түмний ухамсар ба сэтгэхүйн өвөрмөц онцлогуудыг анх эртний философчид тэмдэглэж байжээ. Епикур нь Геродотод бичсэн мэндчилгээдээ: “Ард түмэн бүр өөрийн өвөрмөц мэдрэхүйтэй ба өөрийн өвөрмөц сэтгэгдэлтэй болдог, хүний мэдрэхүй ба сэтгэгдлийн нөлөөний улмаас бий болсон агаарыг өвөрмөц маягаар хүмүүс хэрэглэдэг бөгөөд мөн ард түмний оршин сууж буй газрын ялгаа нь мөн нөлөөлдог”¹ гэж тэмдэглэжээ.

Эллин, перс ба бусад улсуудын ертөнцийг төсөөлөхуйн үйл ажиллагааны ялгааг Геродот “Түүх”² хэмээх өөрийн томоохон бүтээлдээ мөн тэмдэглэжээ. Янз бүрийн улсуудын өвөрмөц араншингий талаар Тацит ч мөн тэмдэглэж байжээ. Жишээ нь: “Германы нутаг дэвсгэрт оршин сууж буй омгууд нь бусад омгуудтай гэр булийн замаар холилдоогүй, эрт дээр үеээс анхны цэвэр ариун байдлаа хадгалсан ба зөвхөн өөрөө өртэйгээ л ижил ард түмэн”³ гэж тэрээр бичжээ.

Ахмад Плиний өөрийн “Байгаалийн түүх” бүтээлдээ янз бүрийн ард түмэн, амьдарч буй газар болон хоорондын харилцаанаас хамааран тэдний зан авир ба сэтгэхүйн ялгааг дурьдажээ. Ксенофонт нь Кирагийн дайн тулааны тухай бичихдээ (перс, вавилон) янз бүрийн ард түмний ертөнцийг төсөөлөхуйн талаар тэмдэглэж байжээ.

Платоны “Филеб” гэдэг харилцан ярианд менталитеттэй хамааралтай сэтгэлхүйн зарим онцлогуудыг тэмдэглэжээ. Тэрээр “Уг онцлогодуудад агуулагдаж буй олон тооны юмс шинжүүд нь сэтгэхүйг ч гэсэн тодрхой бус болгож байна”⁴ гэжээ. Аристотель нь сэтгэхүй бол зөвхөн юмс болон тойрон хүрээлж буй бодит байдлыг танин мэдэхээс гадна хүний дотоод ертөнц, сэтгэхүйг өөрийн, түүний бүрэлдүүлж чадах хүч гэж үзэж байжээ.

Эртний философиid менталитетийг угсаатан, үндэсний онцлог ба сэтгэхүйн гносеологийн категорийн хувьд далд байдлаар илэрхийлж байсан гэж хэлж болох юм.

Дундад зуунд “менталитет”-ийг ойлгох асуудлыг шашин, сүнс, теоцентризмын үүднээс үздэг байжээ. “Бий болсон ертөнц нь зөвхөн эргэцүүлэн бодож байгаа хүмүүсийн асуултан хариулдаг: тэрээр өөрийн дуу холойгоо өөрчилдоггүй, түүнийг зөвхөн харж байгаа мөн хархаас гадна асуулт тавьдаг хүнд адилхан нэг дүрээр харагддаг ба бүгдэйтэй нь ярьдаг боловч уг гадаад ертөнцийн дуу хоолойг өөрийн дотор оршиж буй үнэнтэй харьцуулснаар ойлгодог”⁵ гэжээ.

Шинэ үед шинжлэх ухааны мэдлэг нь нилээд боловсронгуй болж, танин мэдэхүйн асуудал нь тэргүүлэх байр суурийг эзэлж эхэлсэн билээ.

Танин мэдэхүйн үнэн, үнэний хандлага (критерии), танин мэдэхүйн арга, рациональ шинж г.м. гносеологийн асуудлууд Ф.Бэкон, Ж.Локк, Лейбниц, Р.Декарт, Д.Юм ба бусад мэргэд нарын сонирхолыг татаж байсан юм.

Барууны философиid менталитетын асуудал нь онтологийн аспектээс угсаатны хавтгай руу хувиран орсон юм. Энд Ш.Монтескье⁶ и Ж.Бюффоны⁷, узэл бодлыг тэмдэглэх . . .

¹ Философия от античности до современности. М.2004.с.1093.

² Геродот. История. В 9-ти кн./ М. 2001.с.752.

³ К.Тацит. Анналы. Малые произведения. История.М.2004.с.986.

⁴ Платон.Апология Сократа.:Собрание сочинений.Т.1.М.,1994.с.114

⁵ Августин Аврелий.Исповедь// Абеляр П. История моих бедствий. М. 1992.с.132-133

⁶ Монтескье Ш.Л. О духе законов. М. 1999.

нь зүйтэй юм. Ш.Л.Монтескьеийн “Хуулийн тухай санаа” хэмээх бүтээл нь М.Блок, Л.Ле.Февр, Леви-Брюль, Г.Бутулийн концепцуудад менталь шинжийн онолын өмнөтгол болсон юм.

Монтескье уг бүтээлийн арван дөрөвдүгээр бүлэгт оюун ухааны хэв маяг ба сэтгэл хөдлөл янз бүрийн цаг уураас хамааран өөр өөр байдаг учраас хууль ч гэсэн сэтгэл хөдлөлийн ба хэв маягийн ялгаанд зохицох ёстай гэж чухал санаануудын нэгийн тэмдэглэжээ².

Ийм учраас, менталитет хэмээн ойлголт хүн, ард түмний субъектив ба объектив үйл ажиллагаанд нь тусгагдаж байдаг өөрийн дотор сэтгэхүйн үйл ажиллагааны үйл явцыг тусгадаг философи, түүх, социологи ба сэтгэлзүйн олон тооны категориас үүсэн гарч ирсэн гэж хэлж болно.

¹ Бюффон Ж. Всеобщая и частная естественная история.ч.1-10.

² Монтескье Ш.Л. о духе законов. М. 1999. С.189.